

**ЭМИЙН ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГО БАТЛАХ ТУХАЙ  
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙГ АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ  
БЭЛТГЭСЭН ТАЛААР НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ  
УХААНЫ БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2014 оны 6 дугаар  
сарын 25-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн  
Д.Сарангэрэл**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эмийн талаар төрөөс баримтлах бодлого батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганы 2014 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Эмийн талаар төрөөс баримтлах бодлого батлах тухай тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны 2014 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаар хийж, гаргасан санал дүгнэлтийг Та бүхэнд танилцуулж байна.

Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны 2014 оны 5 дугаар сарын 07-ны өдрийн 08 тоот тогтоолоор Эмийн талаар төрөөс баримтлах бодлого батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэлээр ахлуулан байгуулж, ажиллуулсан бөгөөд Ажлын хэсэг 3 удаа, дэд хэсэг 5 удаа тус тус хуралдаж, төслийн талаарх саналын томьёоллыг бэлтгэж, Байнгын хорооны хуралдаанд танилцуулж, санал хураалгав.

Түүнчлэн Ажлын хэсэг эрүүл мэнд, эм зүйн салбарын удирдах ажилтнууд, эмийн холбооны удирдах зөвлөлийн гишүүдтэй уулзалт зохион байгуулж, тэдний саналыг авснаас гадна “Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын шинэчлэл” сэдвээр хэлэлцүүлэг зохион байгуулж, эмийн үйлдвэр, эмийн сан, эмнэлгийн дотоод эмийн сангийн үйл ажиллагаатай танилцсан болно.

Ажлын хэсэг тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг бэлтгэхдээ төслийн хэлэлцэх эсэхийг хэлэлцэхэд Улсын Их Хурлын гишүүдээс асуусан асуулт, гаргасан саналуудыг судалж, төсөлд тусгахыг зорьсон.

Тус Байнгын хорооны хуралдаанаар төслийн анхны хэлэлцүүлгийг хийх явцад Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь, Ё.Отгонбаяр, С.Одонтуяа, А.Тлейхан, Л.Энх-Амгалан нар хөдөө орон нутгийн хүн амыг шаардлагатай эмээр хангах, үйлчлэх

зорилгоор сумын эмийн эргэлтийн санд төрөөс дэмжлэг үзүүлэх, эм хангамжийн зөвшөөрлийн тогтолцоог хүнд сурталгүй, боловсронгуй болгох замаар өрсөлдөөнийг дэмжиж, эмийн үнийг бууруулах, хэрэглэгчийг сонголт хийх боломжоор хангах гэсэн зарчмын зөрүүтэй саналыг гаргасан.


Ажлын хэсгийн болон Байнгын хорооны хуралдаан дээр Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулж, дэмжсэн саналын томьёоллыг Та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрөөс эмийн талаар баримтлах бодлого батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА



Д.БАТЦОГТ